



МОНГОЛ УЛС
ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГА

45059 Дархан, Дархан-Уул аймаг,
Утас: 7037-8023, Факс: 7037-7121,
И-мэйл: info@darkhan.gov.mn
Вэбсайт: www.darkhan.gov.mn

2022.12.14 № 1-10/945

танай _____ -ны № _____ -т

Г ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯМАНД 7

Эдийн засаг, хөгжлийн сайд болон Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2022 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн биелэлтийг боловсруулж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт: хуудастай.



4522101735

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД БОЛОН ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД 2022 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2022 он

Дархан-Уул аймаг

| № | Үйл ажиллагаа | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | | | | | Биелэл т% |
|--|--|-------------------------------|-----------------|-----------------|-----------|--|--------------|
| | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хугацаа | Биелэлт | |
| Арга хэмжээ-1: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх тайлагнах ажлын хүрээнд: | | | | | | | |
| 1.1 | "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх чилэлд хамтран ажиллах | 17 арга хэмжээ | - | 2 | Бүтэн жил | <p>"Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр орон нутагт хэрэгжүүлэх 20 заалтас аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан давхардсан тоогоор 13 заалт, тусгагдаагүй 7 заалтыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.</p> <p>Терийн бүтээмжийн сэргэлтэд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нэмж тусгуулах саналыг мен өдрийн хуралдаанд танилцуулан, дэмжигдсэн.</p> <p>"Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд:</p> <p>4.1.3 Алслагдсан баг хорооллын хүүхдүүдэд зориулсан автобусны тусгай үйлчилгээнд парк шинэчлэлтийг хийж 56 хүүхдийн суудалтай сурагчдын 4 шинэ автобусыг 800.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авч 8 маршрутад үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>3.2.2: Дархан төмөрлөгийн үйлдвэр нь менежментийн гэрээгээр ажиллах хугацаанд хүчин чадлын 20 хувийг ашиглаж байсан. Засгийн газрын шийдвэрээр 2022 онд "Дархан Төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК болсон. 2021 онд "Монгол Ган цогцолбор I" төслийн ТЭЗҮ боловсруулагдаж дууссан. Хонгор сумын Тэмөртолгойн уурхай, Сэлэнгэ аймгийн Худэр сумын Тэмөртэйн уурхайг тушиглэн Монгол Ган цогцолбор I төслийг</p> | 100% |

| | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|
| | | | | | <p>хэрэгжүүлэхэд үйлдвэрийн барилгын ажлын өргөтгөлд шаардагдах 24 га газрын асуудлыг шийдвэрлэсэн.</p> <p>3.4.1: “Дархан арьс ширний цогцолбор” үйлдвэрийг байгуулснаар 7500 орчим байнгын ажлын байр, жилдээ 10 сая.ш арьс шир боловсруулах 13 үйлдвэр, 10 мянт ноос боловсруулах ноос, ноолуур угаах самнах үйлдвэр, түүний цэвэрлэх байгууламж, инженерийн дэд бүтцийн барилга байгууламж бий болох бөгөөд эрчим хүч, усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, дулаан хангамж, уурын зуух зэргийг барьж байгуулахад 15.4 сая ам долларын хөрөнгө оруулалтыг хийж, эрчим хүч 95%, дэд станц ажил гүйцэтгэл 90%, ус, дулаан хангамж 70%, бохир ус цэвэрлэх байгууламжийн аэро-танк зэрэг ажлууд хийгдсэн.</p> <p>4.2.2: 2022 онд шинээр хэрэгжүүлэх арга хэмжээнд “Аюулыг мэдээлэх систем” аппликайши болон сайтыг хүлээн авч хэрэглэгчдэд нэвтрүүлсэн. “И-Дархан” болон “Эрсдэл Дархан” систем ашиглалтад орсноор Төрийн байгууллагуудад хамааралтай өргөдөл гомдол, санал хүсэлтийг ерөнхий админаас төрийн байгууллагууд руу шилжүүлэх зэрэг цахим ашиглалтыг сайжруулах сургалт, иргэдэд сурталчилгаа мэдээллийг тогтмол түгээн ажиллаж байна. Систем ашиглалтын зөвлөгөө зааврыг утсаар болон цахимаар ёгч ажиллаж байна.</p> <p>3.5.5: Бус орон нутгийн тээвэр, ложистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар, зураг, төсөв боловсруулах ажил хийгдэж байна.</p> <p>4.2.2:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дархан-Уул аймагт шинэ суурьшлын бус болох “Залуус хороолол 1, 2” төслийн дэд бүтцийн ажил Улсын төсвийн 47.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байна. 2. Дулаан Дамжуулах сүлжээний ТК.27-ТК.39 худгийн хооронд дулааны магистрал шугамын өргөтгөл, их засварын ажлыг 8.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэж байна. 3. ТК80-ТК94 хүртэлх дулааны шугамын шинэчлэлтийн ажлыг Улсын төсвийн 2.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэж | |
|--|--|--|--|--|--|--|

байна. Тус ажил хэрэгжсэнээр Төрийн болон Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Арьс шир боловсруулах үйлдвэрийн дулаан хангамжийн эх үүсвэр бүрэн шийдвэрлэгдэнэ.

5. Их дээд, мэргэжлийн сургуулиудын консорциумын үйл ажиллагааг бодлогоор дэмжих ажлын хүрээнд Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа АгроЭкологи, бизнесийн сургуулийн барилгын их засвар /Дархан-Уул, Дархан сум/ 2,900.0 сая төгрөгөөр, Шинжлэх ухаан, техникийн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн барилгын их засвар /Дархан-Уул, Дархан сум/ 300.0 сая төгрөгөөр, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Анагаахын сургуулийн дотуур байрны барилгын их засвар /Дархан-Уул, Дархан сум/ 700.0 сая төгрөгөөр, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн барилгын өргөтгөл “Спорт заалны барилга” /Дархан-Уул, Дархан сум 13 дугаар баг/ 1,277.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэж байна.

4.3.3: Төвлөрсөн дулаан хангамжийн чанар хүртээмжийг нэмэгдүүлж, айл өрхийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд: Дархан сумын 5, 7, 8-р багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлууд ашиглалтад орж, эхний ээлжид 7, 8-р багийн Нарантолгойн нийт 28 айл ИШС-д холбогдоод байна.

6, 7-р багийн гэр хорооллын шугам 7.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хийгдэж ашиглалтад орсон.

6, 7-р багт газрыг дахин төлөвлөн барилгажуулах өндөр орон сууц барихаар төлөвлөж хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 75.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар боловсруулсан. Тосгон чиглэлийн гадна дулааны шугам Ф219x7.0мм, Ф159ммх4.5мм-ийн голчтой 1350м урттай шугам, төвлөрсөн цэвэр, бохир усны шугам шинээр татагдсан. Ингеснээр 480 хүүхдийн суудалтай сургуулийн барилга төвлөрсөн дэд бутцэд холбогдсон багаад 2023 онд Өрхийн эмнэлэг, Багийн төв, цэцэрлэгийн барилгыг холбохоор төлөвлөөд байна. Дархан-Уул аймагт шинэ суурьшлын бус болох “Залуус хороолол 1, 2” төслийн дэд бутцийн ажил Улсын

төсвийн 47.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байна.

4.4.1: Орхон суманд 50000 м² газрыг өвлийн хүлэмжийн аж ахуйн цогцолбор байгуулахаар баталсан байна. Мен 3 аж ахуйн нэгжид 113 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн. 2021 онтой харьцуулахад малын тэжээлийн ургамал тариалсан талбайн хэмжээ 30 га-аар нэмэгдэж, 970 га талбайд тариалсан. 2021 онд бэлтгэсэн 180 тонн буюу 9000 боодол ногоон тэжээлийг 2022 онд 148 фермер, малчдад нийлүүлсэн.

5.2.1: Дархан хотын цэвэрлэх байгууламж ашиглалтад орсноор лагийн иж бүрэн боловсруулалттай, /лагийг угсгүйжүүлэх, хатаах/ биологийн 3-р шатны цэвэрлэгээтэй иж бүрэн цэвэрлэх байгууламж болно. Дархан сумын Малчин багт байрлах цэвэрлэх байгууламжийн ойролцоо байdag Хүдэр боловсруулах үйлдвэр нь өөр дээрээ гүний худагтай "Дархан-Ус суваг" ХК-ийн шүүх талбайн картыг ашиглах гэрээтэй. Шаардлага гарсан үед биопрудын талбайн уснаас авч ашигладаг. Ашигласан, хэрэглэсэн усаа дахин ашиглахын тулд шүүх талбайн картыг ашиглаж байна. Дархан сумын 1-р багийн ус түгээх 2-р худгийг төвлөрсэн цэвэр усны шугам хоолойд холбох ажил хийгдсэн.

5.3.1: 2022 онд Азийн хөгжлийн банкны МОН9206 ядуурлыг бууруулах төслийн хүрээнд 158.0 сая төгрөгийн санхүүжилтээр 5 ширхэг хог хаягдлыг ангилах контейнерыг 1,2,3 баг, 7 баг, 12 баг, 16 баг, НААУГазарт тус тус байршуулсан. Орон нутгийн төсвийн 0,33 тэрбум сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын "Бараат" төвлөрсөн хогийн цэг буюу 6-р багт бүх төрлийн хог хаягдлыг 1200°C -д шатааж устгах ОХУ-н "ИЖТЕЛ" шатаах зуух нийлүүлэх ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна. Орон нутгийн төсвийн 0.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын гүйцэтгэл 90 хувьтай, мөн 0.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар аюултай хог хаягдлыг шатаах зуух барилгын ажлын гүйцэтгэл 95 хувийн

гүйцэтгэлтэй байна. Улсын тесвийн 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн ажлын сонгон шалгаруулалт зарлагдаж гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан. Ажлын гүйцэтгэл 20% биелэлтэй байна.

5.4.2: Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагааг 7 удаа явуулж 8.6 мм тунадас нэмэгдүүлсэн бөгөөд үр ашгийн тооцоогоор 53.5 сая төгрөгийн үнэ бүхий 2.677 мянган м/куб хүрын усыг оруулснаар хуурайшилтын зэрэг буурч ой хээрийн түймэр гарыагүй. Мен хөрсний чийгийн хангамж нэмэгдэж бэлчээрийн ургамал, буудайн ургац сайнаар нөлөөлсөн. Ногоон Дархан-2032" хетелбэрийн хүрээнд 788724 урт/м хашаажуулалт хийж, Шинэ иргэний төгөлд авто зогсоол 2 байршилд, гэрэлтүүлэгт 32ш, тохижилтын ажлуудыг хийсэн.

3.4.4: 2022 оны аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт /оны үнээр/ 232.1 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 118.0 (33.7%) тэрбум төгрөгөөр буурсан, мах махан бүтээгдэхүүн, арьс шир боловсруулах, ширэн эдлэл, эсгий бүтээгдэхүүн, алт, металл боловсруулах үйлдвэрлэл тус тус буурч, нүүрс, дулаан, цахилгаан, усан хангамж, темс хүнсний ногоо, мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний борлуулалт өссөн. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2022 оны эхний 10 сард урьдчилсан гүйцэтгэлээр 294.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мян үеэс 27.1 (10.1%) тэрбум төгрөг өссөн.

4.2.5: Европын холбооноос зарласан тесел сонгон шалгаруулалтад Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим засаглалыг бэхжүүлэх, хотын ногсон хөгжил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилго бүхий "Найрамдал-Дархан хотод тэгш, уян хатан, шинэлэг өсөлтөд суурилсан Европын Холбоо-Монголын найрамдлыг бэхжүүлэх" тесел шалгарч З жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Тус теслийн хүрээнд Европын Холбооны улсуудтай шинэ хамтын ажиллагааг өргөжүүлэхээр ажиллаж байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал Бүгд Найрамдах Турк улсын арьс шир

| | | | | | | | |
|-----|--|-----------------|-----------|---|-----------|---|-----|
| | | | | | | <p>боловсруулдаг бус нутаг болох Зейтинбурну дүүрэг, Балыкесирын Гөнэн дүүрэгтэй хамтын ажиллагааг эхлүүлэхээр ажиллаж байна. Ажилд зуучлах өдөрлөг-2022" арга хэмжээнд 406 иргэний хамруулж, 258 иргэний ажилд зуучлахад нэн шаардлагатай ахуйн хэрэгцээг хангаж, 12.9 сая төгрөг зарцуулж, 122 иргэний ажлын байранд зуучилсан. Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 84 иргэний төслийг шалгаруулж, 500,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 169 байнгын ажлын байр бий болсон. Байнгын 1430, улирлын-118, түр-337 нийт 1885 ажлын байрыг бүртгэж, мэдээлсэн. Дэлхийн банкны Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр "Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих" жижиг зээл олгох арга хэмжээний хүрээнд 33 иргэнд 300 сая төгрөгийн зээл олгож, 45 ажлын байр шинээр бий болж, 64 ажлын байр хадгалагдсан байна.</p> <p>5.1.1 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон Ногоон Дархан-2032" хөтөлбөр, "Ногоон Дархан төсөл"-ийн хүрээнд аймгийн хэмжээнд 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад санхүүжилтээр 43,7 га талбайг ойжуулахад 86586 ширэг мод, 20 га талбайд хамгаалалтын зуравас байгуулахад 8599 мод, төв суурин газарт 50 га талбайд 21934 мод, нийт 192438 мод, бутыг тарих ажлыг 19031 иргэн, 270 аж ахуйн нэгж, байгууллагууд гүйцэтгэж 883,0 сая төгрөг зарцуулж, орон нутгийн төсвийн 261,7 сая төгрөгийн хөрөнгөөр хашаажуулах ажлуудыг гүйцэтгээд байна.</p> <p>6.1.1 Мэргэжлийн холбоонд эрхээ шилжүүлэн хийлгэх боломжтой төрийн чиг үүргийн талаарх судалгааг хийж байна.</p> | |
| 1.2 | Орон нутагт хөрөнгө оруулалт татах, сурталчлах, мэдээлэл харилцан солилцох | 305 арга хэмжээ | 199 төсөл | 1 | Бүтэн жил | <p>2022 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 238,7 тэрбум төгрөгийн төсөөт өртөгтэй 49 төсөл арга, хэмжээг 68,1 тэрбум төгрөгөөр, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 52,1 тэрбум төгрөгийн төсөөт өртөгтэй 160 төсөл, арга хэмжээг 26,8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх ажил 91,2 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> | 90% |

| | | | | | | | | |
|-----|--|------------------------------|---|---|-----------|--|--|--|
| | | | | | | | Гадаад зээл тусlamжаар Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусlamж "Өвсний үндэс" төслийн хүрээнд Дархан сумын "Энэрэл" сургуулийн барилгын их засварын ажлыг 600.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгээ. Дархан сумын 15-р багт 960 хүүхдийн сургуулийн барилгыг Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр 10.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 40%, Дархан сумын 5-р баг 15-р сургуулийн барилгын 00 засвар, 12-р сургуулийн 00 засварын ажлыг 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгээд байна. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг иргэд олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд цахим орчинд болон иргэд олон нийттэй 8 удаагийн уулзалтыг 4-н сумын хэмжээнд зохион байгуулсан. Аймгийн ИТХ-ын хуралдаанд 2022 оны 6-р сар, 9-р сар, 12 дугаар саруудад аймаг орон нутагт хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг танилцуулж, мэдээллээр хангаж ажиллаа. | |
| 1.3 | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, "Бүсийн хөгжлийн зорилтот хетелбөр"-ийн төсөлд тусгах саналаа аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, батлагдсан хувилбарыг хүргүүлэх, | Боловсруулсан саналын тоо 10 | - | 1 | Бүтэн жил | Төвийн бусэд хамаарах Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгуудын Засаг дарга, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс оролцсон 15 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2022 оны 03 дугаар сарын 29-ны өдөр Улаанбаатар хотод уулзарт зохион байгуулсан. Дархан-Уул аймгаас "Бүсийн хөгжлийн зорилтот хетелбөр"-ийн төсөлд 10 төсөл арга хэмжээг тусгуулахаар саналыг хүргүүлсэн. | 100% | |
| 1.4 | Аймаг нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж батлуулах | 178 | - | 1 | Бүтэн жил | Дархан-Ууд аймгийг 2022 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөгөөр 159 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж гүйцэтгэл 90.4% буюу 4.52 оноогоор үнэлэгдсэн. Дархан-Уул аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 48 тогтооюур баталсан. 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар Дархан-Уул аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг тодотон 6 булэг 178 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. | 100% | |
| 1.5 | Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн | Тайлан илгээсэн | - | 1 | Бүтэн жил | "Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн /2021 оны | 100% | |

| | | | | | | | |
|---|--|------|--|------|-----------|--|------|
| | үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг холбогдох журамд заасан хугацаанд ИТХ-аар хэлэлцүүлэн баталгаажуулж, танилцуулын хамт хүргүүлэх. | ЭСЭХ | | | | хэрэгжилт/ 104 арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд 2022.01.21-ны өдөр байршуулж, мөн өдөр баталгаажууллаа. Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоослоор баталсан журмын дагуу 2022 оны хэрэгжилт, хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайланг 2023 оны 01 сард хүргүүлнэ. | |
| Арга хэмжээ-2. Эдийн засаг, хөгжлийн яамны цахим мэдээллийн системд хөгжлийн индексийн мэдээллийг 2021 оны байдлаар шинэчилж оруулах | | | | | | | |
| 2.1 | Эдийн засаг, хөгжлийн яамны цахим мэдээллийн системдүүдийг орон нутгийн холбогдох мэдээллээр тогтмол хангаж ажиллах | | | 100% | Бүтэн жил | Xөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан /development.gov.mn/-д Дархан-Уул аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Дархан-Уул аймгийг 2022 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдийг байршуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Аж үйлдвэрийн нэгдсэн зураглал гаргах, аж үйлдвэрийн цахим мэдээллийн сан бий болгох ажлын хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Сангиллын үйлдвэрийн тооллого явуулах ажлын хэсгийг 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тооллогын талаар уулзарт, цахим хурлыг зохион байгуулж, нийт 60 үйлдвэрлэгчдэд мэдээлэл хүргэж, гарсан 10 санал хүснэгтийг нэгтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон Үндэсний хөгжлийн газар тайлагнаасан. Үйлдвэрийн тооллогод хамруулахаар давхардсан тоогоор 167 аж ахуйн нэгж байгууллагад мэдээллийг хүргэж, Сангиллын үйлдвэрийн судалгааг аймгийн Татварын хэлтэс, ГХБХБГ, Санхүү, териин сангийн хэлтэс зэрэг байгууллагуудаас авч нэгтгэн нийт 178 үйлдвэрийн мэдээллээс 86 боловсруулах үйлдвэрийн мэдээллийг шинэчлэн Монгол Улсын аж үйлдвэрийн цахим мэдээллийн сан /industry 4.nda.gov.mn/-д байршуулсан. Дархан-Уул аймагт Улс болон орон нутгийн тэсвийн хөрөнгө оруулалтаар 199 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна. Хувийн хэвшлийн болон гадаад зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрт хөрөнгө оруулагчаас гаргасан гомдол байхгүй болно. | 100% |

| | | | | | | | |
|--|---|--|---|-----|-----------|--|------|
| 2.2 | Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим системд сумдын хөгжлийн индексийн мэдээллийг 2021 оны байдлаар шинэчилж оруулах: www.ldi.nda.gov.mn | Дархан сүм, Хонгор сүм, Орхон сүм, Шарын гол сүм | - | 330 | Бүтэн жил | Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 01-A/52 дугаар захирамжаар 14 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан. Үндэсний хөгжлийн газрын https://ldi.nda.gov.mn/ -ийн цахим системд 2021 оны аймаг, сумдын хөгжлийн индексийн үзүүлэлтийн мэдээллийг 2022 оны 1 улиралд багтаан шинэчилж байршууллаа. | 100% |
| Арга хэмжээ-3. Орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөгөч нарыг чадавхжуулах ажлын хүрээнд: | | | | | | | |
| 3.1 | Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах сургалтад хөгжлийн бодлого төлөвлөгөч нарыг хамруулах: | 1 | - | 1 | Бүтэн жил | Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулсан "Орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөгчдийн зөвлөлдөх цахим сургалт"-д хөгжлийн бодлого, төлөвлөгөч 8 хүн хамрагдлаа. | 100% |
| 3.2 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын чиглэлийн хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулах, оролцоог хангах | 1 | - | 1 | Бүтэн жил | Дархан-Уул аймагт 2022 оны 08 дугаар сард зохион байгуулсан "Эдийн Засгийн форм"-ыг Эдийн Засгийн хөгжлийн яамтай хамтран зохион байгуулсан. Хүнсний хангамж, аюулгүй байдал зөвлөгөөнийг Ерөнхийлөгчийн Тамгын газар, ХХАЯЯ, ЭЗХЯам, Дархан-Уул аймгийн ЗДТГ хамтран 2022 оны 10 дугаар сарын 16-ны өдер зохион байгуулсан. Дархан-Уул аймаг "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн хүрээнд 4 чиглэлийн 34 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэн ажиллалаа. | 100% |

ТАНИЛЦСАН
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА **Б.АЗЖАРГАЛ**

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН

ДАРГА **П.БАТСҮХ**

ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН:
АЙМГИЙН ЕРӨНХИЙ ЭДИЙН ЗАСАГЧ


Б.БАТСҮХ

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДААС ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ 2022 ОНД ЗАСГИЙН ГАЗРЫН ЧИГҮҮРГИЙГ
ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**


2022.12.12

Дархан

| № | Үнэлгээ | Бүгд /заалтаар/ | Бүгд /тоогоор/ |
|----------------------------|----------------------------------|---|-------------------|
| 1. | Хяналтанд авсан нийт бүлгийн тоо | Нэг, хоёр, гурав | 3 |
| 2. | Хяналтанд авсан нийт заалтын тоо | 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 2.1, 2.23.1, 3.2 | 9 |
| 3. Үнэлгээ | 100% | 1.1, 1.3, 1.4, 1.5, 2.1, 2.23.1, 3.2 | 8 |
| | 90.0% | 1.2 | 1 |
| | 70.0% | - | - |
| | 50.0% | - | - |
| | 30.0% | - | - |
| Ерөнхий үнэлгээ, хувь/оноо | | 98.88% буюу 4.94 оноо | |

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА  Б.АЗЖАРГАЛ

ҮНЭЛГЭЭГ ХЯСААН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА  П.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  О.МӨНХСҮРЭН